



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/28

Сүхбаатар сум

Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1."а", "е", 29.1.6."а", Хууль тогтоомжийн тухай хуулийн 46.3, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2, 17.5, Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 2.6, 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу стандартын шаардлага хангасан кассын машин болон хэвлэх төхөөрөмж хэрэглэх, иргэд үйлчлүүлэгчдэд е-баримт олгох үүргээ аж ахуйн нэгж, байгууллагууд, бизнес эрхлэгч нар хангалтгүй биелүүлж байгаа талаар иргэдийн гомдол, хүсэлт удаа дараа ирж байгаа нөхцөл байдлыг харгалзан тус хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгч иргэдэд, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилгахыг сум, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахгүй байгаа иргэн, аж ахуйн нэгжид хуулийн дагуу холбогдох хариуцлага тооцож, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Цэрэнболд/-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ